БАТЛАВ:

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Х.БАТБОЛД

ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА ХУДАЛДАН АВАХ, 75 ОР
/ХОВД, ЖАРГАЛАНТ СУМ/-Н ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.05.13 Ховд хот

| 1 | Үндэслэл | Шаардлага |
|---|---|---|
| 2 | Барилга байгууламжийн байршил | - Цэцэрлэгийн барилга худалдан авах, 75 ор /Ховд, Жаргалант сум/ |
| 3 | Барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал | - Зориулалт: Цэцэрлэгээр ашиглах боломжтой.<br>- Хүчин чадал: 75 ортой |
| 4 | Барилгын үндсэн бүтээц материал | - Төмөр бетон хийцлэлтэй<br>- Зоорьгүй, 2 давхар |
| 5 | Барилгын суурь | - Төмөр бетон суурьтай байх |
| 6 | Инженерийн шугам сүлжээ түүнийг хангах эх үүсвэр | - Дулааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх<br>- Цахилгааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх<br>- Цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон |
| 7 | Галын аюулгүй байдлын нөхцөл | - Барилга байгуулажийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНБД 21.02.02/<br>- Барилга байгууламжийн галын аюулгүй норм /БНБД 21.01.02/<br>- Утаа мэдрэгч, галын дохиололтой байх |
| 8 | Өрөө танхим | 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга нь 3 бүлэгтэй норм стандартад заагдсан өрөө тасалгаатай байх<br>Барилга байгууламжид зайлшгүй байвал зохих өрөө тасалгаа:<br>Бүлгийн өрөө, хүлээн авах өрөө, хувцас солих өрөө, ор хөнжил хураах өрөө, ариун цэврийн өрөө, гонх, коридор, шатны хонгил, эрхлэгчийн өрөө, эмчийн өрөө, Галтогоо, хүнсний агуулах |
| 9 | Онцгой нөхцөл | Барилга байгууламж:<br>- Бүлгийг хүүхдийн насаар нь ангилж, тус бүрд нь хүлээн авахтай байхаар , 2-оос доошгүй гарцтай байх |

Scanned with CamScanner

| | | |
|---|---|---|
| | | - Нэг ангид 25-30 хүүхэд байхаар бүлгийн тоог тооцсон байх<br>- Ангийн сурагчдын сурах, амрах, тоглох орчин бүрдсэн байх<br>- Бага ангийн хүүхдийн бүлгийн өрөөг 1 дүгээр давхарт байршилтай байх<br>- Хүүхдийн хувцас солих өрөө, үүдний өрөө, ариун цэврийн өрөө зэрэг нь тусдаа байх<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц, пандустай байх<br>Гадна талбай:<br>- Гаднах явган зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдсан байх<br>- Авто замын явах хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу байх<br>- Гадна зам талбайн гэрэлтүүлэгтэй байх<br>- Төв авто замд явган хүний гарц, хурд сааруулагчтай байх<br>- Барилгын аврах гарцыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг саадгүй түргэн аврагдах нөхцөл бүрдсэн байх<br>Инженерийн шугам сүлжээ:<br>- Ангиудын агааржуулалт, салхивчийн нэгдсэн системийг норм нормативын дагуу хийгдсэн байх<br>- Насны ангилалд тохирсон ариун цэврийн тоноглолтой байх<br>- Бүлгийн өрөө тус бүрд хаалганы дээр цэнэг хураагууртай ослын гэрэлтэй байх<br>- Ослын гэрэлтүүлгийг орц, гарц, коридорт хийгдсэн байх<br>- Мэдээлэл харилцаа, холбоо дохиоллын инженерийн шугам сүлжээний хэрэгцээ шаардлагыг хангасан байх<br>- Бүлгийн өрөө тус бүрт камертай байх<br>- Гадна хяналтын камертай байх<br>- Үүдний өрөө болон эрхлэгчийн өрөөнд хяналтын дэлгэцтэй байх |
| 10 | Зургийн төслийн бүрдэл | Барилгын бичгийн иж бүрдэл:<br>- Барилга байгууламж хүлээн авсан Улсын комиссын дүгнэлт<br>- Инженер геологийн дүгнэлт<br>- Байрзүйн дэвсгэр зураг боловсруулах<br>- Онцгой байдлын дүгнэлт<br>- Магадлалын ерөнхий дүгнэлт /Хавсралт дүгнэлтийн хамт/ |

Scanned with CamScanner

| | | |
|---|---|---|
| | | Зургийн төслийн иж бүрдэл:<br>1.Эскиз /Батлагдсан/<br>2. Ажлын зураг /Батлагдсан/<br>- ЕТ-Ерөнхий төлөвлөгөө<br>- БА-Барилга архитектур<br>- ТХ- Технологийн зураглал<br>- ББ-Барилга бүтээц /Бүтээцийн тооцооны хамт/<br>- ХАС-Халаалт агаар салхивч<br>- ЦБУ-Цэвэр, бохир ус<br>- ДГ-Дотор гэрэлтүүлэг<br>- ХТ-Хүчит төхөөрөмж<br>- ХД-Холбоо дохиолол<br>- ГД- Гадна дулаан<br>- УХАТ- Ус хангамж ариутгах татуурга<br>- ГЦ-Гадна цахилгаан<br>- ГХ-Гадна холбоо дохиолол |
| 11 | Архитектур орон зайн төлөвлөлтөнд тавигдах шаардлага хангасан байх | Ерөнхий төлөвлөгөө:<br>- Явган замыг өвлийн улиралд хальтардаггүй гадаргуутай байх<br>- Цэцэрлэгийн гадна жагсаалын талбайтай байх<br>- Ногоон байгууламжийг норм дүрмийн дагуу ба ногоон байгууламжийн талбайн бүсээс гадна нийтийн эзэмшлийн талбайтай уялдсан байх<br>- Авто зогсоол нь хашааны гадна байхаас гадна онцгой тохиолдолд хашаан дотор орж барилга үйлчлэх гарцтай талбайтай ба сурагчдын явган замтай огтлолцохгүй байх<br>- Гадна ил бага хэмжээний спорт талбай, амралтын талбай, хүүхдүүдийн тоглоомын талбайг резинен зөөлөн хавтангаар иж бүрэн тохижуулсан байх<br>- Ерөнхий төлөвлөгөөний элементийг цэцэрлэгийн барилгатай уялдуулан орчин үеийн шаардлагад нийцсэн байх<br>- Аваарын орц гарцтай байх |
| 12 | Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл боловсруулахад ашиглах материал шаардлага хангагдсан байх | Норм, нормативууд:<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/<br>- Олон нийт иргэний барилгын норм дүрэм /БНбД 31.03.03/<br>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНбД 3.01-06-90/<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/<br>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх |

Scanned with CamScanner

| | | |
|---|---|---|
| | | дүрэм<br>- Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-12/<br>Бусад холбогдох норм дүрэм |
| 13 | Санхүүжилт | Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар Барилга байгууламжийг захиалагч байгууллагад акт үйлдэж хүлээлгэн өгснөөр гэрээнд тусгасан санхүүжилтийг нийлүүлэгч талд шилжүүлнэ. |

ХЯНАСАН:
ХОХБТХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЭРДЭНЭБАТ

ЖАРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Б.НЯМДЭЛГЭР

БОЛОВСРУУЛСАН:
ХОХБТХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

Scanned with CamScanner